

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хуралдаж, аймгийн ИТХ-ын даргаар Доноогийн Даваадоржийг төлөөлөгчдийн 100 хувийн саналаар батлагдсан ба аймгийн Засаг даргад О.Амгаланбаатарыг нэр дэвшүүлж, Төлөөлөгчдийн 95,12 хувийн саналаар Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн мэдүүллээ.

Тайлант хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 3 удаа хуралдаж, 6 асуудлыг хэлэлцэг шийдвэрлэлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 97 дугаар захирамжаар тус аймгийн Засаг даргаар Очирбатын Амгаланбаатар томилогдож, үүрэгт ажилдаа орлоо.

Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн, Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан, Улаабаатар хот дахь аймгийн Нутгийн зөвлөл, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг улс төрийн намууд, Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэдийн саналд үндэслэн боловсруулж, Үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналын хамт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүллээ.

Дэлхий нийтэд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын халдвараас сэргийлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, хариу арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Онцгой комисс 7 удаа хуралдаж, аймгийн Засаг даргын шийдвэр гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн төв, сумдын орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлаж аймгийн төвийг тойрсон байнгын 11 пост, 17 сум 2 тосгонд 45 пост, нийт 56 постонд 13 хоногийн

хугацаанд давхардсан тоогоор 598 цагдаагийн алба хаагч, 1352 төрийн алба хаагчийг 24 цагаар ажиллуулж байна.

Тус аймгийн чиглэлд ирсэн тээврийн хэрэгслүүд, иргэдийг бүрэн хяналтад авах, шинжилгээнд бүрэн хамруулах, коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутаг дэвсгэрт 1 постыг ажиллуулж, 3 хоногийн хугацаатай ээлжийг солилцуулж байна.

Орон нутгийн “Миний нутаг” ТВ, “Алтай” радио, Онцгой байдлын газрын [www.ga.nema.gov.mn](http://www.ga.nema.gov.mn) веб сайт, цахим хуудсанд “Маскаа зүүцгээе-2” аяныг өрнүүлж урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, сурталчилгааг 2 удаагийн давтамжтай нийт 24 удаа, “Багц мессеж”-ээр 8 удаа, нийт 2000 иргэнд хүргээд байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн хэмжээнд 12 хяналтын цэгт 444 албан хаагч ажиллаж, тэдний хамгаалах хэрэгсэл, хоол, шатахууны зардалд 39.7 төгрөг, Онцгой байдлын газрын шуурхай штабын бичиг хэрэг, халдвар хамгаалал, ариутгалын зардалд 4,5 сая төгрөг нийт 44,2 сая төгрөгийг Гамшигийн сангаас зарцууллаа.

Аймгийн Засаг дарга болон онцгой комиссын гишүүд сумдын удирдлагуудтай цаг үеийн асуудлаар цахим хурал хийж, коронавирус (Covid-19)-ийн халдвар хамгаалалтын дэглэмийг сайжруулах болон сумдын өвөлжилтийн бэлэн байдлын талаар заавар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн сумдын тулгамдсан асуудлуудыг сонсож шийдвэрлэлээ.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2020 оны 11 дүгээр сарын 06, 07, 08-ны өдрүүдэд тус аймагт амжилттай зохион байгууллаа.

Шалгалт өгөхөөр бүртгүүлсэн 362 иргэнээс 284 иргэн буюу 78,4 хувь нь оролцож, 82 иргэн буюу 28,9 хувь нь тэнцлээ.

Шалгалтын ил тод байдлыг хангах үүднээс шалгалтын үйл явцыг камераар баримтжуулж, шалгуулагч иргэд болон сонирхсон этгээдэд шалгалтын үйл явцыг тухайн дэлгэцээр хөндлөнгөөс ажиглах боломжтойгоор зохион байгууллаа.

Үйлчилгээний нэгдсэн төв нь 162 нэр төрлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс шуурхай хүргэн ажиллаж, 500 иргэн үйлчилгээ авсан байна.

Тайлант хугацаанд 8 өргөдөл ирснээс 5 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдлийн хугацаа болоогүй судлагдаж байна. Шийдвэрлэлт нь 62.5 хувьтай байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд нийт 38 дуудлага хүлээн ирснээс хувийн мэдээлэл өгч E-OFFICE программд бүртгэгдсэн 12 гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч холбогдох байгууллагуудад шилжүүлэн, хяналт тавьж шийдвэрлүүллээ. Хугацаа болоогүй судлагдаж байгаа 4 өргөдөл байна. Шийдвэрлэлт 66.7 хувьтай байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс нийт 506 лавлагаа олгож, төсөвт 588.5 мянган төгрөг төвлөрүүллээ.

Аймгийн Засаг дарга уламжлалт найрсаг хамтын ажиллагаатай БНХАУ-ын Ганьсу муж, Шинжан Уйгарын Өөртөө Засах орны Хами аймгийн дарга нарт хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд уламжлалт найрсаг харилцааг улам бэхжүүлж, нийгмийн бүхий л салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгаагаа илэрхийлэн албан захидал хүргүүллээ.

“Хүргэлт” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 30-ны өдрүүдэд зохион байгуулж 16 сумаас ирүүлсэн 296.0 тн хүнсний бүтээгдэхүүнийг 29 тээврийн хэрэгслээр тээвэрлэж, Улаанбаатар хотод хүргэн, холбогдох иргэдэд түгээлээ.

Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл болон коронавирусийн цар тахалтай холбоотой 2020 онд гарсан аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ хийлээ. Захирамжийн хэрэгжилт 93.22 хувьтай байна.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийн дагуу Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цаг уурын 6 өртөөнд 3 цаг тутамд, цаг уурын 14 харуулд 8 цаг тутамд дэлхийн цаг уурын байгууллагын хөтөлбөрийн дагуу агаарын даралт, агаар, хөрсний гадаргын температур, агаарын чийгшил, хур тунадас, салхи, цасан бүрхүүлийн тархац ба зузаан (цас тогтсон үед), агаарын үзэгдэлд байнгын ажиглалт хийж байна. Мөн гадаргын ус судлалын 4, нуур судлалын 1 харуулд усны түвшин, урсгалын хурд, цас, мөсний үзэгдэл, үерийн түвшний ажиглалт хэмжилт хийлээ.

Алтай хотын агаарт агуулагдаж байгаа хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/ болон азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийн хэмжээг 08, 14, 20 цагуудад тогтмол хэмжиж хэмжлийн үр дүнг 10 хоног тутамд tsag-agaar.mn цахим хуудсанд байршуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний санал асуулгыг “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын дагуу цахимаар явуулж байна.

### ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга 55 шийдвэр гаргаж, захирамжийн илтөд, нээлттэй байдлыг хангах зорилгоор аймгийн албан ёсны [www.govi-altai.gov.mn](http://www.govi-altai.gov.mn) сайтад байршууллаа. Мөн Шилэн дансны тухай хуулийн дагуу гарсан шийдвэрүүдийг байршууллаа.

**Архивын тасаг:** Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 140 иргэнд мал тооллогын болон цалин, тушаалын лавлагаа, 2341 хуудас хуулбар олгон, 3.2 сая төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд төвлөрүүллээ.

Баян-Уул, Дарив, Дэлгэр сумын малын А дансны 24 хадгаламжийн нэгжийн 7045 хуудас баримтыг фотошоп программаар засварлалаа.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад үйлчилж байна.

Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн 240 лавлагааг өгч, 6 иргэний гадаад паспортын захиалга авч, 5 хуулийн этгээдийг шинээр, 78 хуулийн этгээдийг дахин бүртгэн гэрчилгээ олгож, бүртгэлийн цахим мэдээллийн санг тухай бүр баяжууллаа.

Иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 95 мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, бүртгэлийн үйлчилгээний хураамж 529.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүллээ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** Тайлант хугацаанд нийт 618 гүйцэтгэх хуудасны 3096997.3 мянган төгрөгийг биелүүлэхээс 325 гүйцэтгэх хуудасны 876733.7 мянган төгрөгийн гүйцэтгэх баримт бичгийг бодитойгоор биелүүлэн, 293 гүйцэтгэх баримт бичгийн 2220263.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд бодит биелэлт 52.5 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлгийн 145 гүйцэтгэх хуудасны 338868.1 мянган төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг бүрт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 113 хүүхдийн тэтгэлгийн 116130.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, биелэлт 65.5 хувьтай байна. .

Мөн “Төлбөртэй хоригдлын нэгдсэн бүртгэл хөтлөх, хяналт тавих журам”-ын дагуу 13 төлбөртэй хоригдлын гүйцэтгэх баримт бичгээс 4 хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгасан төлбөрийн мөнгийг төлбөр авагчид шилжүүллээ.

Хорих ангид ял эдэлж байгаа 10 хоригдлын 57 гүйцэтгэх хуудасны 94422.2 мянган төгрөгийн хохирол гаргуулахаас 5 хоригдлын 13 гүйцэтгэх хуудасны 10324.3 мянган төгрөгийн төлбөрийг бодитойгоор гаргууллаа.

### ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн төсвийн орлогоор эхний 11 сарын гүйцэтгэлээр 6579.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 7025.6 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 106.8 хувиар биелүүлсэн бөгөөд нийт төвлөрүүлсэн орлогын 69.2 хувийг хувь хүний орлогын албан татварын орлогоор, 17.5 хувийг бусад татвар, хураамжийн орлогоор, 13.3 хувийг татварын бус орлогоор бүрдүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5, Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 1, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 1 нийт 4 тендерийг шинээр, 3 тендерийг дахин зарлаад байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4, нийт 6 ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж хүргүүллээ.

### ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

**Мал аж ахуйн чиглэлээр:** Аймгийн Засаг даргын шийдвэрээр аюулгүйн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах 230 тн өвс, 100 тн хивгэн тэжээл бэлтгэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуй газарт олгож, эхний ээлжийн 70 тонн буюу 3500 боодол өвсийг хүлээн авсан ба аюулгүйн нөөцийн өвснөөс хуваарийн дагуу сумдад 230.5 тн өвс олгоод байна.

**Хүнсний чиглэлээр:** Засгийн газрын хуралдаанаар өвөлжилт хүндэрсэн аймгуудаас экспортод 40.0 тн мах гаргах шийдвэрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн

газартай Жей-Икс-Си-Эс ХХК 100.0 мянган толгой бог мал, Дархан Meat Фүүдс ХХК 48.5 мянган толгой бог мал тус тус худалдан авах гэрээ байгуулан, эхний ээлжийн 6.0 тн ямааны махыг Жей-Икс-Си-Эс ХХК гэрээнд заасны дагуу 3500-5200 төгрөгөөр худалдан аваад байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгааг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

**Мал эмнэлгийн чиглэлээр хийгдсэн ажил:** Улсын төсвийн 11.2 сая төгрөгийг 4 сумын 6 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид олгож, боом өвчний вакцинжуулалтад зарцууллаа.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 1136280 мал хамрагдахаас 1121355 малыг хамруулж, гүйцэтгэл 98.6 хувьтай байна. Мөн бруцеллөз өвчний вакцинжуулалтад 799706 мал хамрагдахаас 763083 толгой малыг хамруулж, гүйцэтгэл 96.0 хувьтай байна.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Мал эмнэлгийн ерөнхий газрын А/76 тоот төлөвлөгөөтэй уялдуулан энэ онд 4675.7 мян.тол мал хамруулахаар төлөвлөж, 3190.47 мянган толгой малыг хамруулж, гүйцэтгэл 70.02 хувьтай байна.

Тайлант хугацаанд Мал эмнэлгийн гарал үүслийн 5384 гэрчилгээ бичигдэж, өдөр тутмын хяналтыг цахимаар хийж байна. Бусад аймаг, сумруу гарсан 2862, гаднаас ирсэн 177, аймаг дотроо 2345 гэрчилгээ бичигдсэн байна.

**Мал эмнэлгийн лабораторид хийгдсэн ажил:** Цээл сумын Дэрстэй, Жаргалан сумын Бүрэн багт галзуу өвчин оношлогдож, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлж ажиллалаа.

Тус аймгийн 2020 оны бэлчээрийн газрын фото мониторингийн судалгааны ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 339 цэгт мониторингийн хээрийн судалгааны ажил хийж, шинээр 3 сумын 18 цэгийг нэмэгдүүлж, мэдээллийг газрын кадастрын мэдээллийн сангийн вэб системд оруулан, дүн шинжилгээ хийж үр дүнг тооцлоо.

2020 онд аймгийн хэмжээнд дундаж ургац биомасс 73.6 кг/га болж 2019 онтой харьцуулахад 36.7 хувиар ургацын хэмжээ буурч, тачир сийрэг болсон нь судалгааны үр дүнгээр тогтоогдлоо.

Аймгийн хэмжээний боломжит даац 2806352 хонин толгой байгаа бөгөөд бэлчээрийн даац 1425541 хонин толгойгоор хэтэрсэн гэж тооцоологдсон нь энэ жил бороо хур бага, ургацын гарц муу байгаатай холбоотой байна.

**ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:** 2020 онд нийт 21 барилга байгууламж, шугам сүлжээний ажлыг гүйцэтгэлийн зураглалаар хүлээн авч байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн шинэчлэлт, баяжилтыг хийлээ.

Тус аймгийн 18 сум 2 тосгон 1 багийн том масштабтай байр зүйн зургийг Монгол улсын MNS 6702:2017 стандартад хөрвүүлж, албан бичгээр хүргүүллээ.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:** Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжиж буй Тонхил сумын ахуй үйлчилгээний барилгын цементийн шинжилгээ хийлээ.

Модон эдлэл, барилгын хийц, материалын үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, [.Kh.ainur@barilga.gov.mn](mailto:Kh.ainur@barilga.gov.mn) цахим хаягаар хүргүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй Цогт сумын Соёлын төвийн барилга, АШУҮИС-ийн харъяа Говь-Алтай аймаг дахь салбар 960 суудалтай сургуулийн барилга, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Алтай хотын орон сууцнуудын гадна фасад засварын ажил, НҮБ-ийн хүүхдийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Бигэр сумын цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж, Цогт сумын сургуулийн дотуур байрны ариун цэврийн байгууламж, душ хийх ажил, Есөнбулаг сумын гэр хороололд бохирын шугам татах ажил, Бугат сумын эмнэлгийн ариун цэврийн байгууламж, душ хийх ажил, Шарга сумын худгийн барилгын ажлуудад тус тус улсын комисс ажиллан, ашиглалтад хүлээн авлаа.

#### ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

##### **Эрүүл мэндийн салбарт:**

Халдварыг эрт илрүүлэх, тандалт хийх зорилгоор нэмэлтээр 5000 ширхэг түргэвчилсэн оношлуур татан авч, 616 хүнээс сорьц авснаас ковидын халдвар илрээгүй болно. Энэ хугацаанд Улаанбаатар болон бусад орон нутгаас ирсэн 450 иргэнийг гэрийн тусгаарлалтад хянаж, 29 хүний ажиглалтын хугацаа дууссан учир хяналтаас хасаад байна. Захирамжийн дагуу эрүүл мэндийн албыг идэвхжүүлж 24

цагийн үйл ажиллагаанд шилжүүлэн, Шуурхай штабын жижүүрийн хуваарийг гарган, багийн ажилчдыг 24 цагаар жижүүрийн үүрэг гүйцэтгүүлж байна.

Эрүүл мэндийн штабын 70484067 дугаарын утсыг 24 цагаар ажиллуулж, иргэдийн 500 гаруй дуудлагад хариу өгч, Улсын онцгой комисс, холбогдох газруудыг мэдээллээр ханган ажиллаж байна.

Коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах Шуурхай штаб, Удирдлагын баг, Нийгмийн эрүүл мэндийн төлөвлөлт хяналтын баг, Хариу арга хэмжээний баг, Санхүү, хангалтын баг, Захиргааны баг, коронавируст халдвар /Ковид-19/-ын тохиолдол илэрсэн үед голомтод үүрэг гүйцэтгэх Шуурхай хариу арга хэмжээний бүрэлдэхүүнийг тус тус байгуулан ажиллаж байна. Багууд 24 цагаар жижүүрлэж, 2 удаа хуралдаж хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2 цагийн байдалд ажиллах 65 үйл ажиллагааг цагийн байдлаар төлөвлөж гаргалаа. Татан авалтын бүлэг аймгаас Улаанбаатар хот болон бусад аймагруу явах 276 иргэний бүртгэлийг авч шинжилгээ авах нэмэлт 3 цэгийг байгуулан бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Тандалтын бүлэг Алтайн Хүдэр ХХК-ийн 558 ажилтнаас хурдавчилсан оношлуурын шинжилгээ авахад Ковид-19-ын халдвар илрээгүй.

Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалын дагуу эрсдэлийн үнэлгээг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хийхэд “Маш өндөр” үнэлэгдлээ.

Эрсдэлт бүлгийн 9400 хүний судалгааг нэгтгэн ЭМЯ-нд хүргүүллээ. Үүнд: Аймгийн хэмжээнд 0-5 насны хүүхэд 5608, 65-аас дээш насны хүн 699, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2616, хорт хавдартай иргэн 430, сүрьеэтэй иргэн 41, гемодиализ эмчилгээ хийлгэж байгаа иргэн 6 байна.

COVID-19 халдварын сорьц авах, түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх талаар цахим сургалтыг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр 17 эрүүл мэндийн байгууллагын 80 эмч, лаборант, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгууллаа.

2020 оны тархвар судлалын 48 дугаар долоо хоног буюу 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд амбулаториар 1493 үзлэг хийснээс томуугаар өвчлөгсдийн 67.6 % нь 15 хүртэлх насны, үүнээс 83.3% нь 4 хүртэлх насны хүүхэд эзэлж байна.

#### **Нийгмийн даатгалын чиглэлээр:**

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 9035 хүнд 2919.2 сая төгрөгийг олголоо.



Шинээр тэтгэвэр тогтоолгосон хүсэлт гаргасан өндөр настан 18, тахир дутуу 7, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, нийт 26 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 59 хүнд 94.0 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 32 хүнд 4.3 сая, оршуулгын тэтгэмж 6 хүнд 6.0 сая, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 17 даатгуулагчид 39.6 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 49 иргэнийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 172 иргэнийг хамруулж, ЭМД-ын санд 6.4 сая төгрөг хуримтлагдлаа.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: Аймгийн хэмжээнд 909 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд 52 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна.

**Нийгмийн халамжийн сангийн мэдээлэл:** Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас нийт 592.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүллээ. Үүнд:

- Халамжийн тэтгэвэр 995 иргэнд 299.0 сая.төг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 1033 иргэнд 88.9 сая.төг
- Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 222 иргэнд 33.4 сая.төг
- Ахмад настны хөнгөлөлт тусламж 61 иргэнд 8.7 сая.төг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 88 иргэнд 6.3 сая.төг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 480 иргэнд 23.5 сая төгрөг
- Алдарт эхийн одонтой эхийн тэтгэмж 1 эхэд 0.1 сая төгрөг
- Өрх толгойлсон эхийн тэтгэмж 2 иргэнд 0.5 сая төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмж 1 өрхөд 2.0 сая төгрөг
- Цалинтай ээжийн тэтгэмж 2563 иргэнд 125.2 сая төгрөг
- Алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 4.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо.

**Боловсрол, соёл, урлагийн чиглэлээр:**

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан сургуулийн дотуур байранд байсан 180 хүүхдийг аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу гэрт нь хүргэх ажлыг зохион байгууллаа.

Сургуулийн өмнөх боловсролын 20 цагийн сургалтад 2571 хүүхэд буюу 65.7 хувь, ерөнхий боловсролын сургуулийн 175 цагийн хичээлд 7763 хүүхэд буюу 66.1 хувь нь теле хичээлд хамрагдаж байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:**

Орон нутагтаа амьдарч буй хариуцлагатай, амьдралын зөв дадал хэвшилтэй, үр хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлж байгаа залуу манлайлагч гэр бүлийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх “Хайрын түүх” цуврал нэвтрүүлгийн эхний дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлан мэдээг хүлээн авч, “Шилдэг эцэг эхийн зөвлөл”-ийг журмын дагуу шалгаруулан, шагнаж урамшууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.7 –д заасан чиг үүргийн дагуу хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийг хуралдуулан “Шуурхай үйлчилгээний баг”-ийг 24 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан “Хариу арга хэмжээ авч ажиллах тухай” 11 заалт бүхий төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Дотуур байрны хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хоол хүнс, ариутгал халдваргүйжүүлэлтийн байдалд хяналт тавин 4 төрлийн зөвлөмж, 200 ш гарын авлага бэлтгэн тарааж, мэдээллээр ханган ажиллалаа.

### **ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Дэлгэр, Тайшир, Бигэр, Цээл сумдад булаг шандны эхийг хаших, Есөнбулаг сумын Шаврын гол болон Бугат сумын Баян голд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэм тогтоох, мөрдүүлэх, тэмдэгжүүлэн, загон татах, Жаргалан, Шарга сумдад тус бүр 3 га талбайд ойн зурвас байгуулах, “Ногоон паспорт- Ногоон төгөл” аяны хүрээнд Есөнбулаг сумын 3.2 га талбайд хийгдсэн ажлыг өргөжүүлэхээр 1000 ширхэг мод тарьж, сүүдрэвч, явган гүүр байгуулах зэрэг ажлууд хийгдлээ.

*Зураг 1. Сумдад булаг шандны эхийг хашиж хамгаалсан зураглал*

*Зураг 2. Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоосон зураглал*

*Зураг 3. Ойжуулалтын ажил хийгдсэн байдал*

### НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Монгол Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 01/248 дугаар удирдамжийн дагуу хүнсний үйлдвэр, худалдаа, хадгалалт түгээлтийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 45 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан хийж, 3 төрлийн 110 зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Тус газрын улсын байцаагч нар аймгийн төвд эргүүл шалгалт хийж хөл хорионы дэглэмийг зөрчин, гадуур явж байсан хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, сургуулийн удирдлагуудад хүлээлгэн, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Тус аймгийн авто замын төв постуудад болон нүхэн жорлонд урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийлээ.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Монгол Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу коронавируст халдварын үед эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг үнэлж, аюулгүй байдлыг хангуулахад чиглэсэн хяналт шалгалт хийж, бэлэн байдлыг хангуулан ажиллалаа.

**Нэгдсэн лаборатори:** Лабораторид 6 байгууллага, 11 аж ахуй нэгж, 10 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 24 сорьцод 129 үзүүлэлт, үрийн 1 сорьцод 7 үзүүлэлтээр, ариутгалын бодис усны 1 сорьцод 1 үзүүлэлтээр, төмс хүнсний ногооны 8 сорьцод 36 үзүүлэлтээр, ундны усны 22 сорьцод 113 үзүүлэлтээр хими хор судлал, нян судлал, хорио цээрийн шинжилгээ хийхэд хүнсний бүтээгдэхүүний 5 сорьцод 5 үзүүлэлтээр, ундны усны 7 сорьцод 13 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарлаа.

Шинжилгээний төлбөр 184.0 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлээ.

### ЕС. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОГ АЖИЛ:

**Баян-Уул сум:** Тус сумын Сум дундын эмнэлгийн эмч нар ерөнхий боловсролын сургуулийн 1-12 ангийн сурагчдад урьдчилан сэргийлэх үзлэг хийж, хүүхэд тус бүрт зөвлөгөө өгч ажиллалаа.

Цэцэрлэгийн үндсэн сургалтад 121, хувилбарт сургалтад 40 хүүхэд суралцаж байгаа бөгөөд бүлгийн багш нар бүлгийн эцэг эхчүүд, хүүхдүүдтэй цахимаар холбогдож, эрүүл мэнд, ариутгал халдваргүйжүүлэлтийн талаар зөвлөгөө мэдээллийг хүргэж, эцэг эхчүүд, хүүхдүүд багш нартайгаа өдөр бүр тогтмол холбогдож, багш, хүүхэд, эцэг эхийн гуравласан холбоотойгоор ажиллаж байна.

Тайлант хугацаанд Ховд аймгийн Манхан, Зэрэг сумдын уран бүтээлчидтэй хамтран "Халх захчин түмний аялгуу" тоглолтыг толиллууж, 270 хүн үзэж сонирхлоо. Мөн Баянбогд багийн малчдад уран бүтээлээсээ сонирхууллаа. Алтайн ятга хөгжмийг нутагшуулах түгээн дэлгэрүүлэх зорилгоор худалдан авч, ашиглаж байна.

**Бугат сум:** Багш сурагчдын "Эрдмийн хөг аялгуу" тоглолтыг соёлын төвд халдваргүйтгэлийн дэглэмийг баримтлан зохион байгууллаа.

Ардын дууны уралдаан зохион байгуулж, шилдгүүдээ тодруулж, урамшууллаа.

Соёлын өвийг сурталчилах, хүүхэд залууст эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор "Эх түүхээрээ аялахуй аян"-ыг 11 дүгээр сарын 6-ны өдрөөс 8-ны өдрүүдэд, ерөнхий боловсролын 9-н жилийн сургуультай хамтран монгол наадгай уламжлалт тоглоом "Алаг мэлхий" өрөх, "Хорол" тоглоомуудын зан үйлийг сурталчилах, зааж сургах, түгээн дэлгэрүүлэх ажлыг 5, 6-р ангийн сурагчдын дунд тус тус зохион байгууллаа.

**Тайшир сум** : “Хүүхдээ сонсох цаг”-ийг 11 сарын 6 нд зохион байгуулан сургуулийн удирдлага, хичээл заагч багш нар сурагчдын асуултад хариулан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэн ажиллалаа.

Хөл бөмбөгийн талбайн нээлтийг амжилттай зохион байгуулан аймгийн төвийн 2-р сургуулийн баг тамирчид, Дэлгэр сумын баг тамирчид, аймгийн БСУГ-ын дэргэдэх дасгалжуулагч багш болон шигшээ багийн тамирчид, тус сумын хөл бөмбөгийн багийн тамирчдын дунд нөхөрсөг тэмцээн зохион байгууллаа.

Насанд хүрэгчдэд монгол бичгийн сургалт зохион байгуулж, анхан, дунд шатанд нийт 37 төрийн албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

**Эрдэнэ сум**: 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 13 дэлгүүрээс хүнсний нөөцийн болон захиалгын судалгаа авч, хүнс барааны үнийг тогтвортой байлгах, цар тахалтай холбоотой ямар нэгэн асуудал гарахад сумыг хүнсний нөөцийн хомсдолд оруулахгүй байх зорилгоор захиалга авч нэгдсэн журмаар хүнсийг татах ажлыг зохион байгуулахаар шийдвэрлээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран “Малчдад ээлтэй төр” хүмүүнлэгийн төслийн ажлыг тус сумд хэрэгжүүлэн, 2020 оны 11 сарын 01-ний өдрөөс 11 сарын 12-ны өдрүүдэд хээрийн бойг зохион байгуулан, тус сумын Цагаан уул, Сангийн далай, Цэцэг нуур, Өлзийт багийн 82 малчин өрхтэй гэрээ байгуулан, дундаас доош тарга хүчтэй 144 толгой хонь, 4576 толгой ямаа, нийт 4720 толгой малыг нядалж, гулууз, дайвар бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн ангилж, арьс нэхийд анхан шатны тордолт, мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын бие төлөөлөгчид хүлээлгэн өглөө.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

